

**“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 07/22

Улаанбаатар хот

**Компанийн зарласан хувьцаанаас
гүйлгээнд нэмж гаргах тухай**

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2, 33 дугаар зүйлийн 33.3, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, Булигаар ХК-ийн дүрмийн 7.7.3 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссын тогтоолын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. Компанийн нэмж гүйлгээнд гаргах энгийн хувьцааны тоог 140'000'000 (нэг зуун дөчин сая) хүртэлх байхаар тогтсугай.
- Хоёр. Компанийн гүйлгээнд нэмж гаргах энгийн хувьцааны тоо, нийтэд санал болгох үнэ, хугацаа, хувьцаа нэмж гаргахтай холбоотой аливаа асуудлыг шуурхай шийдвэрлэн ажиллахыг эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



А.ЭНХМЭНД

**“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 08/22

Улаанбаатар хот

**“Ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр”
(ESOP) батлах тухай**

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссын тогтоолын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**


- Нэг. Компанийн “Ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр” (ESOP)-ийг хавсралтаар баталсугай.
- Хоёр. Хөтөлбөрийн дагуу хуулийн этгээдийн бус сан байгуулах, сангийн үйл ажиллагааны журам гаргаж батлах, санд компаниас оруулах хөрөнгийн хэмжээг тогтоох эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөл /А.Энхмэнд/-д зөвшөөрсүгэй.
- Гурав. “Ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр”-т хамрагдах ажилтнуудын урамшууллын хэмжээг тогтоох аргачлалыг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Анхболд/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



А.ЭНХМЭНД

“Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны
09 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит бус хурлын
08/22 тоот тогтоолын хавсралт



АЖИЛЛАГСДАД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР /ESOP/

“Булигаар” ХК өөрийн компанийн ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр (ESOP) хэрэгжүүлэхээр танилцуулж байна.

Энэхүү хөтөлбөр нь ажилчдадаа компанийн энгийн болон давуу эрхийн хувьцаа эзэмшүүлэх замаар олгох урамшууллын нэг хэлбэр юм.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ компанийн нийт ажилтан, албан хаагчдыг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд бус сан байгуулан сангийн хувьцаа эзэмшүүлэх, уг санд компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааг байршуулах замаар хөрөнгөжүүлэн сангийн хувьцаа эзэмшигч ажилтан, албан хаагчдын ажлын байрны гүйцэтгэлийн чанар, хариуцлагыг үнэлэн улирал, жилээр сангийн хөрөнгөөс урамшуулал олгох зорилготой.

Компани 3-аас дээш жил тогтвор суурьшилтай ажилласан, хөдөлмөрийн гэрээтэй ажилчдыг хөтөлбөрт хамруулах, цаашид шаардлагатай гэж үзсэн гэрээт ажилтнуудыг хамруулах боломжтой байхаар төлөвлөж байна.

Олон улсад хэрэгжүүлсэн туршлагыг авч үзвэл хөтөлбөр хэрэгжүүлсэн компаниуд хэрэгжүүлээгүй компаниудтай харьцуулахад илүү амжилттай ажилладаг бөгөөд эдгээр компанийн ажилчдын цалин ижил чиглэлийн бизнесийн үйл ажиллагаа явуулдаг компаниудтай харьцуулахад 10-15 хувийн илүү үр бүтээмжтэй, урамшуулалтай байдаг.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь компанийн ажилчдад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах, улмаар компанийн удирдлагад ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх, компанийн засаглалыг сайжруулах, мэргэжлийн хүний нөөцийг чадавхжуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой.

КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД БОЛОН АЖИЛЧИД ЭРХ АШГАА НЭГТГЭН, НЭГ ЗОРИЛГОТОЙ АЖИЛЛАСНААР КОМПАНИ ИЛҮҮ АМЖИЛТАД ХҮРЭХ БОЛОМЖТОЙ.

Хөтөлбөрийн гол зорилго нь компанийн ажиллагсад ажилдаа илүү хариуцлагатай, өөриймсөг, бүтээмжтэй, тогтвор суурьшилтай ажилласнаар компанийн хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, нэгж бүтээгдэхүүний өртөг хямдарч, чанар стандарт сайжирснаар бизнесийн үйл ажиллагаа, ашгийн түвшин нэмэгдэх юм.

Бүтэц

- Итгэмжлэлийн сан байгуулах; (нийт ажилтан, албан хаагчид байгуулах)
- Сангийн үйл ажиллагааг журмаар зохицуулах;
- Ажилчид сангийн хувьцаа эзэмшигч байх бөгөөд өөрийн нэр дээр данстай байх;
- Итгэмжлэгдсэн төлөөлөгч санг удирдах.

Санхүүжилт хийх хэлбэр

1. Бэлэн мөнгө:

- a. Компани эхний ээлжинд санд бэлэн мөнгө байршуулж, сан тухайн хөрөнгөөр компанийн гүйлгээнд гаргаж буй энгийн болон давуу эрхийн хувьцаанаас худалдаж авна.
- b. Энэ төлбөр нь компанийн татвар ногдуулах орлогоос хасагдана.
- c. Компани ашигтай ажилласан тохиолдолд сангийн хувьцааны тоо, хэмжээнд таарсан ашгийг хуваарилан олгох ба сан ажилчдад эзэмшиж буй сангийн хувьцааны тоогоор дансанд нь ногдол ашгийг хуваарилна.

2. Үнэт цаас гаргах;

3. Ажилчид сар, улирал, жил бүр тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалыг сангийн хөрөнгө рүү шилжүүлэх хэлбэрээр бүрдүүлэх.

Компани санхүүжилт хийх дээрх хэлбэрүүдээс эхний ээлжинд тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг санд шилжүүлэн нэмж гүйлгээнд гаргах энгийн болон давуу эрхийн хувьцаанаас сан худалдан авах замаар сангийн хөрөнгийг эхлүүлэх хэлбэрийг сонгохоор төлөвлөсөн.

Мөн энэхүү санхүүжилтийг олгохдоо ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн компанийн өнгөрсөн хагас жилийн тайлант хугацааны үйл ажиллагааны ашгаас санхүүжүүлэх болно. Мөн компани хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам боловсруулж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах бөгөөд хөтөлбөрт хамрагдах ажилчин тус бүртэй гэрээ байгуулж, хэрэгжилтэд ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо хяналт тавьж ажиллана.

Сангийн үйл ажиллагаа тодорхой хугацааны дараа улам идэвхжиж, хөрөнгийн хэмжээ нэмэгдсэнээр компанийн инженер техникийн ажилтнууд, ажилтан, албан хаагчдыг гадаад улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг, хамтран ажилладаг компаниуд дээр богино, дунд хугацааны сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар мэргэжилтэй ажилтнуудын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэхэд анхаарал хандуулахаар төлөвлөж байна.